



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/111

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний 318 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр улиралд зарцуулах Засаг даргын нөөц хөрөнгийн 30 хувь болох 21.000.000 /хорин нэгэн сая/ төгрөгийг COVID-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээ авахад зарцуулсугай.

2. COVID-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг зохион байгуулахад Булган сум, Булган боомт аймгийн Онцгой комиссын даргын шийдвэрээр томилогдсон Шуурхай ажлын хэсгийн алба хаагчдын томилолт, шатахууны зардал 3.916.500 төгрөг, Цагдаагийн газрын алба хаагчдын томилолт, шатахууны зардал 5.372.930 төгрөг, Онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр тушаалаар Хөшөөтийн уурхай, Цэцэг, Алтай, Булган сум, Булган боомт дээр Онцгой байдлын газрын даргаар ахлуулсан ажлын хэсгийн болон Онцгой байдлын газрын алба хаагчдын томилолт, шатахууны зардал 3.069.500 төгрөг, Зооноз өвчин судлалын төвөөс ариутгал халдваргүйтгэлийн бодис, сурталчилгааны материалын зардал 1.564.000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/111 Ch  
02 00683